**“ЭВИДЕНСЕ-АУДИТ” ХХК**

Аудит, хөрөнгийн үнэлгээ,аутсорсинг
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
9-р хороо, 7-р хорооолол, Алтайн гудамж, 281,
Хойморь оффис, 502 тоот, Регистр № 5211875,
Утас, факс: 976-7000-7121
E-mail:info@evidenceaudit.mn

Огноо:2023 оны 02 сарын 15 № 5 /2023

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК-ийн Удирдлагад

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

### *Санал дүгнэлт*

Бид “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн (цаашид “Компани” гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

- 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан
- Энэ өдрөөрх жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

Бидний дүгнэлтээр, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### *Дүгнэлтийн Үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *“Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага”* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх  зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ Санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

С.БАДАМГАРАВ
ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК
Хоймор оффис 502 тоот Алтайн гудамж
Сүхбаатар дүүрэг, 9-р хороо,
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо 2023.02.25

## "ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
## АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тод | 2022.12.31 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | 5 | 122,433,811,189 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 6 | 118,770,852,772 |
| **Нийт ашиг (алдагдал)** | | **3,662,958,417** |
| Түрээсийн орлого | | 53,224,834 |
| Бусад орлого | 7 | 6,232,046,337 |
| Борлуулалт маркетингийн зардал | 8 | 7,569,594,517 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 9 | 1,870,799,449 |
| Санхүүгийн зардал | 10 | 135,890,111 |
| Бусад зардал | 11 | 4,943,587,372 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 12 | (2,369,509) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 13 | 396,568,874 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | | **(4,970,580,246)** |
| Орлогын татварын зардал | 14 | - |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | | **(4, 970,580,246)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | | **(4, 970,580,246)** |

"ЭВИДЕНСЕ АУДИТ" ХХК 5211875

*Энэхүү Орлогын дэлгэрэнгүй тайланг 7-оос 35 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.*

"ЭВИДЕНСЕ-АУДИТ" ХХК ХУУДАСНЫ ДУГААР 7

## "ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Тод | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 15 | 380,550,311 | 239,304,333 |
| Дансны авлага | 16 | 1,647,475,003 | 722,559,959 |
| Татварын авлага | 17 | 191,352,553 | 198,958,952 |
| Бусад авлага | 18 | 8,135,751,713 | 7,571,752,648 |
| Бараа материал | 19 | 2,273,329,670 | 4,272,239,429 |
| Урьдчилж гарсан зардал | 20 | 3,059,413,424 | - |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **15,687,872,673** | **13,004,815,321** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө | 21 | 104,909,209,030 | 104,040,543,880 |
| Биет бус хөрөнгө | 22 | 531,381,901 | 648,463,792 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **105,440,590,931** | **104,689,007,672** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **121,128,463,604** | **117,693,822,993** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| **Өр төлбөр** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Дансны өглөг | 23 | 6,104,680,767 | 5,302,903,591 |
| Цалингийн өглөг | | 552,679,699 | 430,686,576 |
| Татвар, НД-ын шимтгэлийн өр | 24 | 1,346,558,174 | 623,514,073 |
| Банкны богино хугацаат өр төлбөр | 25 | 606,255,865 | 394,785,927 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **8,610,174,505** | **6,751,890,166** |
| **Урт хугацаат өр** | | | |
| Урт хугацаат өр төлбөр | 25 | 21,715,493 | 2,734,551,704 |
| Хойшлогдсон татварын өр | | 12,002,611,626 | 12,625,003,223 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **12,024,327,119** | **15,359,554,927** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | | **20,634,501,624** | **22,111,445,093** |
| **Эздийн өмч** | | | |
| Өмч: /хувийн/ | | 1,038,511,577 | 1,038,511,577 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | 93,771,609,671 | 94,122,014,288 |
| Хуримтлагдсан ашиг | | 5,683,840,732 | 421,852,035 |
| **Эздийн өмчийн дүн** | | **100,493,961,980** | **95,582,377,900** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | | **121,128,463,604** | **117,693,822,993** |

*Энэхүү Санхүү байдлын тайланг 7-оосс 35 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.*

"ЭВИДЕНСЕ АУДИТ" ХХК 5211875

"ЭВИДЕНСЕ-АУДИТ" ХХК ХУУДАСНЫ ДУГААР

## “ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Үзүүлэлт | Хувьцаат капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021.12.31** | **1,038,511,577** | **93,771,609,671** | **5,683,840,732** | **100,493,961,980** |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | 350,404,617 | - | **350,404,617** |
| Зарласан ногдол ашиг | - | - | (291,408,451) | **(291,408,451)** |
| Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал/ | - | - | (4,970,580,246) | **(4,970,580,246)** |
| **2022.12.31** | **1,038,511,577** | **94,122,014,288** | **421,852,035** | **95,582,377,900** |

*Энэхүү Өмчийн өөрчлөлтийн тайланг 7-оос 35 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.*

"ЭВИДЕНСЕ-АУДИТ" ХХК

## “ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК
2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2022.12.31 |
|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **118,320,225,711** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 111,931,248,628 |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 26,042,951 |
| Бусад мөнгөн орлого | 6,362,934,132 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **117,073,067,563** |
| Ажилчдад төлсөн мөнгө | 8,914,186,429 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,837,001,188 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 11,289,792,880 |
| Ашиглалтын зардал төлсөн | 36,504,830 |
| Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 1,190,938,245 |
| Хүүний төлбөрт төлсөн | 78,235,021 |
| Татварын байгууллагад төлсөн | 2,670,132,838 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 6,565,844 |
| Бусад мөнгөн зарлага | 90,049,710,288 |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **1,247,158,148** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | - |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **3,670,931,991** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 952,599,984 |
| Биет бус хөрөнгө *олж эзэмшихэд төлсөн* | 25,999,939 |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,692,332,068 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(3,670,931,991)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | - |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **2,826,394,999** |
| Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 2,766,014,370 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | 60,380,629 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **543,867,134** |
| Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 254,860,391 |
| Төрөл бүрийн хандив | 8,500,000 |
| Төлсөн ногдол ашиг | 264,916,774 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | 15,589,969 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн дүн** | **2,282,527,865** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(141,245,978)** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(141,245,978)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 380,550,311 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 239,304,333 |

*Энэхүү Мөнгөн гүйлгээний тайланг 7-оос 35 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт уншиж бөгөөд тодруулгууд нь Санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.*

"ЭВИДЕНСЕ-АУДИТ" ХХК
ХУУДАСНЫ ДУГААР 10